Төрийн нарийн бичгийн даргын
2023 оны 08 дугаар сарын ..12..-ны өдрийн
.57/206....дугаар тушаал ..5... дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ √ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Боловсрол, шинжлэх ухааны яам | Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Тэгш хамран сургах боловсролын хэлтэс |

| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
|---|---|
| Тэгш хамран сургах боловсролын хэлтсийн дарга | Эрхэлсэн түшмэл, ТЗ-3 |

| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
|---|---|
| Ажлын өдөр 8 цаг | 14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр |

| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
|---|---|
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Тэгш хамран сургах боловсролын хөгжлийн бодлогын талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенц, төрийн бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, гүйцэтгэлд судалгаа, шинжилгээ хийж, тэгш хамран сургах боловсролын бодлого, сургалтын хөтөлбөр, үнэлгээ, эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиг үүргийн хүрээнд ажлын гүйцэтгэл, үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Төрийн албаны зөвлөлийн
2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн
352 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| Боловсрол, шинжлэх ухааны яам | Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Тэгш хамран сургах боловсролын хэлтэс |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
| Тэгш хамран сургах боловсролын хэлтсийн дарга | Эрхэлсэн түшмэл, ТЗ-3 |
| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын өдөр 8 цаг | 14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Тэгш хамран сургах боловсролын хөгжлийн бодлогын талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенц, төрийн бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, гүйцэтгэлд судалгаа, шинжилгээ хийж, тэгш хамран сургах боловсролын бодлого, сургалтын хөтөлбөр, үнэлгээ, эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиг үүргийн хүрээнд ажлын гүйцэтгэл, үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Тэгш хамран сургах боловсролын талаар төрөөс баримталж буй бодлого, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
2. Тэгш хамран сургах сургалтын хөтөлбөр, үнэлгээний бодлого, хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенц, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг удирдлагаар хангах;
3. Тэгш хамран сургах боловсролын хүний нөөц, сургалтын байгууллагын хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
4. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын хөгжил, хамгаалал, сургалтын орчин, тохирох хэрэглэгдэхүүний бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Тэгш хамран сургах /хөгжлийн бэрхшээл, үндэсний цөөнх, хэл, соёл, хилийн чинад дахь монгол хүүхэд, сургууль завсардсан хүүхэд, насан туршдаа суралцахуй/ асуудлаар холбогдох хууль тогтоомжид заасан дүрэм журам, аргачлал боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлага, зохион байгуулалтаар хангах; | Хууль тогтоомжид нийцүүлсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 2.Хөгжлийн бэрхшээл, нийгмийн болон хэл, соёлыг ялгаатай хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамран сургах асуудлаар бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, сайжруулах санал хувилбар дэвшүүлэх, төлөвлөх, хэрэгжилтийг удирдлагаар хангах; | Хууль тогтоомжид нийцүүлсэн байна. | Т,Х,Г,Ш |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Тэгш хамран сургах боловсролын талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенц, төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтыг хангах; | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг бодлого, зохицуулалтаар хангасан байна. | Т,Х,Г,Ш |

МОНГОЛ УЛС ЗОВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 2.Тэгш хамран сургах сургалтын хөтөлбөр, үнэлгээний чиглэлээр холбогдох бодлого, хууль тогтоомжид заасан салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт болон богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр, удирдамжийг хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх, боловсруулах, батлуулах хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах; | Захиргааны хэм хэмжээ тогтоох акт нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон захиргааны ерөнхий хуульд нийцсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 3.Салбарын болон үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх богино, дунд хугацааны хөтөлбөр, үйл ажиллагааг төлөвлөх, батлуулах, хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах; | Хүртээмж, үр дүн сайжирсан байна. | Т,Х,Г,Ш |
| | 4.Боловсролын үйлчилгээнд хамрагдах тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн боловсролд хамрагдалтын хэтийн төлөвийг тодорхойлох, холбогдох тооцоо, судалгаа хийж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх; | Судалгаа, тооцоолол хийгдсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 5.Байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд боловсрол эзэмших, хөгжих, нийгмийн үйлчилгээ, сургалтын хэлбэрийг бий болгох, хэрэгжилтийг зохицуулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнд хүрсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 6.Тэгш хамран сургах боловсролын үйлчилгээний орчин, хүртээмжийг нэмэгдүүлэх, хувилбарт сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны төрлийг оновчтой болгох, үр дүнг сайжруулахад чиглэсэн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, шийдвэрийн үндэслэлийг боловсруулах; | Захиргааны хэм хэмжээ тогтоох акт нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон захиргааны ерөнхий хуульд нийцсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 7.Тэгш хамран сургах боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төсөл, хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлох, гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн ажлыг уялдуулах, хэрэгжилтийн удирдлага зохицуулалтыг хангах, салбар дундын болон нийгмийн түншлэлийг бэхжүүлэх; | Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангасан байна. | Т,Х,Г,Ш |
| | 8.Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн боловсролын эрэлт, хэрэгцээ, нийлүүлэлтийн прогнозыг боловсруулах. | Бодлогын зорилтод нийцсэн судалгаа хийгдсэн байна. | Т,Х,Г,Ш |

| | | | |
|---|---|---|---|
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Тусгай хэрэгцээт боловсролын хүний нөөцийн хөгжил, нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээрх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах; | Захиргааны хэм хэмжээ тогтоох акт нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон захиргааны ерөнхий хуульд нийцсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 2.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, ажилтанд шаардлагатай эрх зүйн орчныг бий болгох, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах; | Баримт нотолгоонд үндэслэсэн, тооцоо судалгаа гарсан, бодлогын зорилттой нийцсэн зохицуулалт хийгдсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 3.Хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, давтан сургах талаарх холбогдох бодлого, хууль тогтоомжийн хүрээнд салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт болон богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр, удирдамжийг хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх, шинээр боловсруулах, батлуулах хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах; | Захиргааны хэм хэмжээ тогтоох акт нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон захиргааны ерөнхий хуульд нийцсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 4.Багш ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага хоорондын түншлэлийг хөгжүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх; | Нийгмийн түншлэл, хамтын ажиллагаанд ахиц гарсан байна. | Т,Х,Г,Ш |

| | | | |
|---|---|---|---|
| | 5.Тэгш хамран сургах сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих, үйлчилгээний үр дүнг сайжруулах чиглэлээр хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулах, хэрэгжилтийг удирдлагаар хангах; | Захиргааны хэм хэмжээ тогтоох акт нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон захиргааны ерөнхий хуульд нийцсэн байна. | Т,Х,Г,Ш |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Ялгаатай хэрэгцээт хүүхдийн сурч, хөгжих, хамгаалагдах, нийгмийн амьдралд тэгш оролцох эрхийг хангахад чиглэсэн хууль, тогтоомж, үндэсний хөтөлбөр, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах; | Суралцагчийн эрх хангагдсан байна. | Т,Х,Г,Ш |
| | 2.Сургалтын байгууллагын орчин дахь хүүхдийн хөгжил, төлөвшил, хамгааллын талаарх бодлого, хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенцэд нийцүүлэн нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичигт ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн эрхийг хангах асуудлаар тусгах, боловсронгуй болгох, хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах; | Хууль тогтоомж, богино, дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулсан байна. | Т,Х,Г,Ш |
| | 3.Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг уялдуулан, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах; | Төсөл хөтөлбөрүүд харилцан уялдаатай ажиллаж, үр дүнд хүрсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 4.Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний нийлүүлэлт, хүртээмж, хэрэглэгдэхүүний нийцэд тавигдах шаардлагыг батлуулах, хэрэгжилтийг зохицуулах, үнэлгээ хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах; | Тэгш хамран сургах боловсролын орчны эрх зүйн зохицуулалт сайжирсан байна. | Т,Х,Г,Ш |
| | 5.Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын орчны аюулгүй байдлыг хангах, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хүртээмжтэй байдалд судалгаа, шинжилгээ хийх, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах; | Баримт нотолгоо, тооцоо судалгаанд үндэслэсэн тайлан, зөвлөмж гарсан байна. | Т,Х,Г,Ш |

| | | | |
|---|---|---|---|
| 5 дугаар зорилтын хүрээнд | 1.Хэлтсийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, тайлагнах, биелэлтийг тооцох ажлыг удирдлага, арга зүйгээр хангах; | Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 2.Нэгжийн үйл ажиллагааны стратеги, чиг үүрэгтэй холбоотой бодлого, хууль, тогтоол шийдвэрийн биелэлтийг тооцох ажлыг удирдлага, чиглэлээр хангах; | Хууль тогтоомж, стратегийн зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 3. Удирдах албан тушаалтан, холбогдох байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх; | Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна. | Т,Х,Г,Ш |
| | 4.Албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд удирдлагын дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө, чиглэлээр хангах, хамтран ажиллах; | Нэгжийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 5.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг “Яамны хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах; | Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна. | Т,Х,Г,Ш |
| | 6.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авилгын эсрэг хуулийг мөрдөх; | ХАСХОМ-ийг хуулийн дагуу мэдүүлж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна. | Т,Х,Г,Ш |
| | 7.Төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх; | Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна. | Т,Х,Г,Ш |

**III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА**

| | |
|---|---|
| Боловсрол | - Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй |
| Мэргэжил | - Боловсрол /0111/, багш-тусгай хэрэгцээт боловсрол /011428/, багш, согог судлал, /нийгмийн ажил /092301/ |
| Мэргэшил | - Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх |
| Туршлага | - Төрийн албанд 8-аас доошгүй жил, ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх; |

МОНГОЛ УЛС ... ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | |
|---|---|---|
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах | - тэгш хамран сургах боловсролын бодлогын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;<br>- нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах;<br>- хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх<br>- хэгжийн үйл ажиллагаан дахь эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, дүгнэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хувилбарыг боловсруулах, танилцуулах;<br>- тэгш хамран сургах боловсролын бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах;<br>- бусад |
| | Дүн шинжилгээ хийх | - боловсрол, шинжлэх ухааны салбарын бодлого, стратеги төлөвлөлттэй уялдуулан зохицуулах<br>- салбарын үйл ажиллагаа, үйлчилгээн дэх эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, дүгнэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хувилбарыг боловсруулах, танилцуулах;<br>- салбарыг хөгжүүлэх талаар хэлэлцүүлэг, хурал, семинарийг удирдан зохион байгуулах, чиглүүлэх, оновчтой санал, дүгнэлт гаргах;<br>- сэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон байгууллагын үйл ажиллагаанд системийн дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа хийх;<br>- судалгааны үр дүнг харьцуулан үнэлэх, тайлбарлах;<br>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх;<br>- бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах;<br>- бусад |
| | Асуудал шийдвэрлэх | - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах;<br>- аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль, тогтоомжийн төсөлд тусгах санал боловсруулах;<br>- албан тушаалын чиг үүргийн хүрээнд аливаа асуудлыг хууль, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;<br>- гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;<br>- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах;<br>- бусад |
| | Манлайлах | - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх;<br>- зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх;<br>- шинэлэг санаа, дэвшилтэт арга барил, үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, албан хаагчдын шинэ санал, санаачилга, бүтээлч сэтгэлгээ, хандлагыг дэмжих;<br>- харилцааны өндөр соёлтой байх;<br>- зөрчилдөөнийг эв зүйгээр зохицуулах;<br>- өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх;<br>- нээлттэй шударга байх;<br>- ажлын шинэ арга барилыг нэвтрүүлж, хөгжүүлэх, |

| | | |
|---|---|---|
| | | бүтээлч санаачилгатай байх;<br>- нэгжийн зорилтыг тодорхойлохдоо хамт олны оролцоог хангах, санал авах, тусгах;<br>- хамт олны эерэг нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын менежмент сайтай байх;<br>- багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дүгнэх, нэгжийн хамт олонд танилцуулах;<br>- бусад |
| | Бусад | - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах;<br>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;<br>- албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;<br>- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх;<br>- англи хэл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;<br>- бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;<br>- албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах;<br>- харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх;<br>- төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;<br>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;<br>- жендэрийн тэгш байдлыг хангах. |

**IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга

| | |
|---|---|
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br><br>- шинжээч -1<br>- ахлах мэргэжилтэн-1<br><br>Нийт: 2 | Бусад харилцах субъект:<br>- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс;<br>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;<br>- Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага. |

**V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

| | |
|---|---|
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |

| | |
|---|---|
| Албан тушаал:<br><br>АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ<br><br>.................... /Ш.НАРАНТУЯА/<br>(Гарын үсэг)<br><br>2023 оны 08 дугаар сарын 18 -ны өдөр | Байгууллагын нэр:<br><br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br><br>Шийдвэрийн огноо: 23 08 14<br><br>Дугаар: 352 |
| Албан тушаалын тодорхойлолт баталсан: | |
| Байгууллагын нэр:<br><br>БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ<br><br>Шийдвэрийн огноо: ....................................<br><br>Дугаар: ...............<br><br>(тамга/ тэмдэг)<br>ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА<br>.................................................... /....................................../<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>2023 оны 08 дугаар сарын 18 -ны өдөр | |